

#### Сэтгэл бахдам

#### байгууллага болохын төлөө

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus  
Vol. 198 (2022.03)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Монголын РКК  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Бид хамтдаа Рисшо Косей Кай нийгэмлэгийн 60 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүллээ.

Тэндай урсгалын тэргүүн асан Ямада Этай гуай “Нивано та үнэнхүү чин сэтгэлээсээ зүтгэдэг учраас олон хүмүүс таныг дагах нь аргагүй биз. Эгэл сүсэгтэн олон ингэж их зүйлийг хийж бүтээж байгаа нь үнэхээр талархмаар зүйл шүү” гэж хэлж байсан удаатай.

Бид хүн бүрийг аз жаргалтай болгож чадах сургаалтай учирч, түүнийгээ бусадтай хуваалцья гэсэн сэтгэлээр зөвхөн сургаалыг түгээхийн төлөө өөрсдийгөө умартан зүтгэж ирсэн. Энэ нь гишүүд бидний амьдралын утга учир, бахархал юм. Косей Кай нийгэмлэгийн эрч хүчний ундарга энд оршдог гэж хэлж болно.

“Ромын ард иргэд Ромыг агуу болохоор нь хайрлаагүй. Ард иргэд нь Ромыг хайрладаг байсан болохоор Ром агуу болсон юм” гэж Английн шүүмжлэгч Честэртоны хэлсэн үг бий. Энэ маш чухал зүйл. Рисшо Косей Кай нийгэмлэг цаашид улам бахархам сайхан байгууллага болон өсөн дэвжихэд гишүүд та бүхний хүчин зүтгэл нэн чухал билээ.

«Үүсгэн байгуулагчийн үг» 11, X126-127

## Аз жаргалын талбайд үр цацах нь (Өглөг, 3-р хэсэг)

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Энэрэн нигүүлсэхүйг хэрэгжүүлэгч Цү Чи сан

Буддын энэрэн нигүүлсэхүйг хэрэгжүүлэгч “Цү Чи” хэмээх Тайваний буяны байгууллага байдаг юм. 2007 онд Ниваногийн нэрэмжит энх тайвны шагналыг хүртсэн Чэн Ен багштан 1966 онд үүсгэн байгуулж байсан ба тухайн үедээ жижигхэн сайн дурын нийгэмлэг байсан бол одоо гамшгийн тусламжаас авахуулаад олон салбарт сайн дурын үйл ажиллагаа явуулдаг 4 сая гаруй гишүүнтэй буддын олон улсын төрийн бус байгууллага болтлоо өргөжин тэлсэн.

Тус байгууллагын нэр нь “Энэрэл нигүүлслээр хүмүүсийг аврах” гэсэн утгатай ба манай нийгэмлэгийн нэгэн адил Цагаан лянхуа судрын сургаалд тулгуурлан бурханы энэрэн нигүүлсэх сэтгэлээр хамаг амьтныг аврах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Энэ байгууллагын талаар миний хамгийн ихээр гайхан биширсэн зүйл бол “Тусламж дэмжлэг шаардлагатай хүмүүс байгаагийн ачаар бидэнд сайн үйлс хийх боломж олддог” гэсэн тэдний үзэл санаа юм. Сайн дурын үйл ажиллагаа, хандивын үйлээр дамжуулан энэрэн нигүүлсэх сэтгэлээ хөгжүүлдэг ба түүндээ талархах сэтгэл, баяр баясал нь үйл ажиллагааных нь хөдөлгүүр болдог гэхээр үнэхээр гайхамшигтай. Манай нийгэмлэгийн “Нэг хоолоо хандивлая хөдөлгөөн”-ийг санагдуулам энэхүү үзэл санааны эх үндсийг өгүүлэх тус нийгэмлэг дөнгөж байгуулагдаад байх үеийн түүх одоо ч яригддаг. Чэн Ен гуай сүсэг нэгт гишүүддээ хулсан сав өгөөд “Хоолныхоо мөнгөнөөс багаханыг хэмнээд энэ саванд өдөрт 5 жяо (нэг юаний хоёрны нэгтэй тэнцэнэ) хийж хуримтлуулцгаая” гэжээ. Тэгтэл нэг хүн “Өдөр бүр хийж байхаар нэг мөсөн сард 15 юань хийчихвэл болох юм биш үү?” гэж асуув. Багштан ийнхүү хариулсан гэдэг: “Өдөр бүр 5 жяо хийх болгондоо хүмүүсийн сайн сайхны төлөө залбирах чухал. Өдөр бүр хэмнэх 5 жяо маань бусдыг хайрлаж, авран хамгаалах энэрэн нигүүлсэхүйн сэтгэл болон хуримтлагдах юм.”

Өглөг, тэр дундаа эдийн өглөгийн талаар эргэцүүлэн буй бид бүхэнд энэ үзэл санаа маш чухал, сургамжтай зүйл болов уу гэж бодож байна.

## “Ач буян”-ыг арвижуулдаг байгууллага болохын төлөө

Зовлон бэрхшээлтэй учирсан хүнд тусалснаар хүн өөрөө ч аврагдаж, аз жаргалтай болдог. Хүмүүс үүнийг ойлгож мэдэрсэн учраас л чин сэтгэлээсээ баярлаж талархан өглөг хандив өргөдөг биз ээ. Мөн тэр мөнгөө өдөр бүр бага багаар тууштай цуглуулах чухал. Өмнөх дугаарт “Эд мөнгө хуримтлуулан өглөг хандив өргөх нь амьдралын зорилго ч, утга учир ч болж болно” гэж хэлсэн нь ийм учиртай. Өглөгийн үйл хийснээр өөрийн төлөө хийгээд бусдын төлөө үйл нэгэн цогц болдог. Энэ л хүн болж төрсний хамгийн том жаргал гэсэн үг юм.

Тэгэхээр их хэмжээний мөнгө хандивласнаар л их ач буян хураан аз жаргалтай болдог гэсэн үг биш. Буддын нэгэн сударт “Хичнээн ядуу хүн байсан ч, сүсэг бишрэлт сэтгэлээр бусдад сайн сайхныг өгөх аваас тэр хүмүүн амар амгалан болно” гэж тодорхой бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл сэтгэл санаа баяр баяслаар бялхан, амар амгаланг олох гэсэн ач буяныг эдэлнэ гэсэн үг. Хүн бусдын баярлан инээмсэглэх царайг хараад сэтгэл дүүрч, сэргэх мэдрэмжийг авдаг ба тэр нь амьдралынх нь эрч хүч болдог. Тэрхүү аз жаргалын мэдрэмжийг дахин амтлахыг хүсэн өөрийн эрхгүй дахин өглөг өргөх сэтгэл төрдөг байж болох юм. Тийм биш гэж үү?

Дээр үеэс манай байгууллагыг аз жаргал, ач буян арвижих “Аз жаргалын талбай” гэж хэлдэг байсан. Тэнд өглөг хэмээх “үр”-ийг цацсанаар хожим ач буян нь дэлгэрнэ гэсэн утгатай. Гишүүдийн нандин чухал “өглөгийн үр”-ийг бусад хүмүүсийн аз жаргалын төлөө зарцуулж, ач буяныг нь арвижуулах нь байгууллагын үүрэг. Гишүүдийн хүсэл мөрөөдөл, залбирал, энэрэл нигүүлсэхүй бүгд шингэсэн өглөгийн үрийг жинхэнэ утга учрынх нь дагуу ашиглаж, үнэ цэнийг нь гаргаж чадаж байгаа эсэхээ одоо дахин нэг нягталж үзэцгээе.

Үйл ажиллагаагаараа бардамнан, өөрсдийгөө л мундаг гэж бодоогүй биз? Үргүй зардал гаргаагүй байгаа? Тусламжийн дуу хоолойд хүрч ажиллаж чадаж байгаа билүү? Гишүүд сургаалаас баяр баяслыг мэдэрч чадаж байгаа юу? Эдгээрийг нухацтай эргэцүүлэн бодож, өглөг хандивт нягт нямбай хандвал зохилтой. Косей кай нийгэмлэг хэмээх “Аз жаргалын талбай”-г хамтдаа боловсруулж, үр цацан бурханы үйлд шамдаж буй хүмүүсийн аз жаргал үүнтэй нягт холбоотой. Байгууллагын ойн баярын сар тохиож буйтай холбогдуулан үүнийг дахин гүн гүнзгий ухамсарлах нь зүйтэй болов уу.

*“Косей” сэтгүүл, 3-р сарын дугаар*

# Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

## Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх

### Рисшо Косей Кай дэлхийд түгэн дэлгэрсэн нь

Тус нийгэмлэг Японд төдийгүй Америк, Бразил, Англи, Тайвань, Тайланд, Солонгос, Энэтхэг, Непаль зэрэг улсуудад хэдэн арван салбартай болоод байгаа ба гишүүд аз жаргал, дэлхийн энх тайвны төлөө бурханы үйлд шамдаж байна. Дотоод гадаадын шашны байгууллагын төлөөлөл олон хүмүүс Рисшо Косей Кай нийгэмлэгийн сургаал, үйл ажиллагааг сонирхон нийгэмлэгээр зочлон ирдэг юм. Ердөө гучаадхан гишүүнтэй үйл ажиллагаагаа эхэлсэн тус нийгэмлэг дэлхий даяар гишүүдийн хүрээгээ тэлж байгаа нь Үүсгэн байгуулагч, Мёокоо багштан, Нивано ерөнхийлөгчийн сургаал хичнээн гайхамшигтай болохыг илтгэнэ.



#### ● Бяцхан мэдлэг

Лянхуан Гурамсан Судрыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх зорилгоор Үүсгэн байгуулагчийн бичсэн “Лянхуан Гурамсан Сударын шинэ тайлбар”, “Буддизмын амь Цагаан лянхуа судар” зэрэг номнуудыг гадаад хэл дээр орчуулсан байдаг.

## Нивано ерөнхийлөгч ном өвлөж авсан нь



Ерөнхийлөгч Нивано Ничикоо 1938 онд Үүсгэн байгуулагчийн ууган хүү болон мэндэлжээ. Үүсгэн байгуулагч дайны үеэс авахуулаад дайны дараа хүртэл Токиод байсан тул тэрээр хэдий нас балчир ч ээждээ тусалж, дүү нараа харж хандан Сүганүма тосгонд 10 жил амьдарчээ. Дараа нь гэр бүлээрээ Токиод амьдрахаар болоход Үүсгэн байгуулагчийн сургаалаар маш олон хүн аз жаргалтай болж байгааг хараад аавынхаа гайхамшигт үйлийг ойлгосон гэдэг.

Тэрээр 1991 онд Үүсгэн байгуулагчаас ном залгамжлан авч нийгэмлэгийн хоёр дахь ерөнхийлөгч болжээ.




### Бяцхан мэдлэг

Нивано ерөнхийлөгч 1944 оноос хойш 10 жил ээж, дүү нарын хамт Сүганүма тосгонд амьдарчээ. Энэ хугацаанд Үүсгэн байгуулагч Токиод бурханы зам мөрд шамдаж байсан гэдэг.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.





## Олон улсын хэлтсийн даргын булан

### Өглөгийн үйлээр дамжуулан мэдрэх аз жаргал

Энэ сарын айлдвараар дамжуулан өглөг, ялангуяа эдийн өглөгийн тухай тунгаан, шашин шүтлэгтэй хүний хувьд өдөр бүрийг хэрхэн өнгөрүүлж буйгаа эргэцүүлэн бодох боломж олдсон.


Айлдварын эхний хагаст дурьдсан Цү Чи сан бол Тайваний буддын шашны төрийн бус байгууллага бөгөөд үүсгэн байгуулсан Чэн Ен багштан Ниваногийн нэрэмжит энх тайвны шагнал хүртсэнээр тус байгууллагатай ойр дотно харилцаатай болсон юм. Дээр үед Нивано ерөнхийлөгчийн саналаар тухайн үеийн Ватанабэ дарга ахлан бидний хэдэн ажилтад шашны байгууллагын удирдлагын талаар суралцахаар айлчлан очиж байлаа. Цү Чи сан бол гамшгийн тусламж үйл ажиллагаанаас авахуулаад эмнэлэг, их сургууль, байгаль орчныг хамгаалах төсөл зэрэг үйл ажиллагаа явуулдаг буяны мэргэжлийн байгууллага юм. Үйл ажиллагаагаа өөрсдийнхөө телевизийн сувгаар цацаж, Тайваний нийгэмд буяны үйлсийн үндсийг тавьж байгааг хараад маш их биширч байснаа санаж байна.

Бид нийгэмд сайн сайхныг бүтээж буй Цагаан лянхуа судрыг гол судраа болгодог буддын шашны бусад байгууллагаас сурч, өглөгийн үйлээр дамжуулан нигүүлсэнгүй сэтгэлээ хөгжүүлж, өглөг хандивын талаарх ойлголтоо эргэн дүгнэж, эгэл даруу байхын мөн чанарыг ухаарч, өнөө цагийн өөрсдийн итгэл үнэмшил, чиг хандлагаа эргэн харах нь зүйтээ хэмээн Нивано ерөнхийлөгч сургажээ. Энэ сард байгууллагын 84 жилийн ой тохиож буйтай холбогдуулан өглөг хандивын үйлийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж, өөрөө төдийгүй өрөөл бусдын хамтаар аз жаргалыг мэдрэхийн төлөө сургаал номоо түгээн дэлгэрүүлцгээе.



We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA  
 TEL: 1-650-359-6951 Email: [lotusbuddhist@gmail.com](mailto:lotusbuddhist@gmail.com)  
 URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
 TEL: 1-212-867-5677 Email: [rky39@gmail.com](mailto:rky39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
 TEL: 1-773-842-5654  
 Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
 Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
 URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567  
 Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org)  
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai International

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA  
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745  
 Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)  
 URL: <http://rksabuddhistcenter.org>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
 TEL: 1-253-945-0024 Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)  
 URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
 Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>

**在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai**  
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

**在家佛教韓國立正佼成會釜山支部**

**Korean Rissho Kosei-kai of Busan**  
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

**社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei**  
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

**台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan**  
台灣台南市東區崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

**Rissho Kosei-kai South Asia Division**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

**Rissho Kosei-kai Society of Kolkata**

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

**Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,  
West Bengal, India

**Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center**

Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,  
Bihar, India

**Rissho Kosei-kai of Patna Dharma Center**

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

**Rissho Kosei-kai of Central Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

**Rissho Kosei-kai of Singapore**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai of Phnom Penh**

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

**RKISA Rissho Kosei-kai International of South Asia**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai of Bangkok**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

**Rissho Kosei Dhamma Foundation**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

**Rissho Kosei-kai Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL: 880-2-41360470

**Rissho Kosei-kai Mayani**

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Damdama**

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Satbaria**

Village: Satbaria Bepari Para, Chandanail, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Chendhirpuni**

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai Raozan**

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Laksham**

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

**Rissho Kosei-kai Dhaka North**

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

**Rissho Kosei-kai Cox's Bazar**

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

**Rissho Kosei-kai Patiya**

**Rissho Kosei-kai Ramu**

**Rissho Kosei-kai Aburkhill**

**Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia  
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia  
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Erdenet**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

**Rissho Kosei-kai of Paris**

**Rissho Kosei-kai of Venezia**

**Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK  
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>  
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>  
Twitter: [https://twitter.com/rkuk\\_official](https://twitter.com/rkuk_official)  
Instagram: [https://www.instagram.com/rkuk\\_official](https://www.instagram.com/rkuk_official)

**Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)**

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>